



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (495)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Прокурорын зэрэг дэвийн нэмээдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Биржийн нэр зарлах тухай*
- *Эрүүл мэндийн даатгалын 2007 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Додоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны тавдугаар сарын 14

№18 (495)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 222. | Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 35 | 417 |
|------|---|-----------|-----|

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 223. | Чиг үүрэг батлах тухай | Дугаар 80 | 418 |
| 224. | Журам, жагсаалт батлах тухай | Дугаар 81 | 421 |
| 225. | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 82 | 423 |
| 226. | Ажилд томилох тухай | Дугаар 83 | 423 |
| 227. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 85 | 423 |
| 228. | Ой угтсан бүтээлч ажлын тухай | Дугаар 86 | 428 |
| 229. | Биржийн нэр зарлах тухай | Дугаар 88 | 428 |
| 230. | Эрүүл мэндийн даатгалын 2007 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай | Дугаар 91 | 429 |
| 231. | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны тухай | Дугаар 96 | 429 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 232. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлах тухай | Дугаар 21 | 432 |
| 233. | Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай | Дугаар 22 | 432 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 05 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Прокурорын байгууллагын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

нэмэгдэл олгох журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Энэ тогтоолыг 2007 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Прокурорын албан тушаалын зэрэг дэвийн

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2007 оны
35 дугаар тогтоолын хавсралт

ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВИЙН НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ

1.1. Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийг хувиар тооцон сар бүр олгоно.
түүний албан тушаалын үндсэн цалингаас дараахь

Зэрэг дэв	Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	Төрийн хууль цаазын шадар зөвлөх	Хууль цаазын итгэмжит зөвлөх	Хууль цаазын ахлах зөвлөх	Хууль цаазын зөвлөх
Нэмэгдлийн хувь	33	31	29	26	23

1.2. Прокурор сахилгын шийтгэл хүлээж зэрэг дэв нь буурсан бол түүнд сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс эхлэн зэрэг дэвийн нэмэгдлийг буурсан зэрэг дэвээр олгоно.

1.3. "Хууль цаазын зөвлөх" -ийн зэрэг дэвтэй прокурорт сахилгын шийтгэлтэй байгаа хугацаанд нь зэрэг дэвийн нэмэгдэл олгохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Чиг үүрэг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ хавсралт ёсоор баталсугай.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолын хавсралт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРОЛЦОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

1. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид "санаачилга" гэх)-ын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.1. санаачилгын тайлангийн маягт, түүнийг гаргах болон нийтэд мэдээлэх зааврыг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн талаар татварын болон орон нутгийн байгууллагад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

1.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (гадаадын хөрөнгө оруулалттай, хувийн хөрөнгө оруулалттай, төрийн өмчийн оролцоотой, хамтарсан үйлдвэр зэрэг бүх хэлбэрийн аж ахуйн нэгж)-ээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөр

зэргийг тайлангийн маягт, зааврын дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон нэгтгэн гаргасан мэдээг Үндэсний татварын ерөнхий газраас гаргуулан авч хянах.

1.3. мэдээ буруу гаргасан бол холбогдох байгууллага, албан тушаалтнаар дахин гаргуулах.

1.4. Үндэсний татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээг үндэслэн санаачилгын Засгийн газрын тайланг маягтын дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон улсын хэмжээгээр эцэслэн хянан албажуулж, санаачилгын бие даасан ажлын албанд хүргүүлэх;

1.5. улсын болон орон нутгийн төсөвт олборлох үйлдвэрлэл эрхлэгчдээс хүлээн

авсан албан татвар, төлбөрийн улсын хэмжээгээр гаргасан Засгийн газрын тайланг нийтэд мэдээлэх;

1.6. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллах.

2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачилгын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэдгээрийг санаачилгад хамруулах;

2.2. санаачилгыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулийн төсөл боловсруулах;

2.3. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт бодлого, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллах.

3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачилгын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн эсэх, аж ахуйн нэгжээс байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа, байгаль орчинд учруулсан хохирол зэргийг ил тод нийтэд мэдээлэх.

4. Үндэсний татварын төв байгууллага санаачилгын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1. бүх шатны татварын байгууллага, татварын байцаагч, холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлага, ажилтан нарыг санаачилгын тайлан гаргах талаар мэргэжил арга зүйгээр хангах, зохион байгуулах;

4.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөрийн талаархи мэдээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аймаг, нийслэл, холбогдох төрийн захиргааны байгууллагаас орон нутгийн татварын байгууллага, байцаагчаар дамжуулан аж ахуйн нэгж бүрийн нэрээр хүлээн авч хянан нэгтгэх;

4.3. мэдээ буруу гаргасан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтнаар дахин гаргуулах;

4.4. аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон улсын хэмжээний мэдээг санаачилгын холбогдох маягтын дагуу гаргаж Сангийн яаманд мэдээлэх;

4.5. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

5. Гаалийн төв байгууллага санаачилгын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс хүлээн авсан гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар болон үйлчилгээний хөлсний хэмжээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

6. Ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санаачилгын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулах;

6.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага болон бүртгэл, санхүүгийн ажилтанг санаачилгын тайлан гаргах арга зүй, заавраар хангах;

6.3. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс хүлээн авсан тусгай зөвшөөрлийн болон бусад төлбөр, үйлчилгээний хөлсний талаархи мэдээг санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гарган Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх;

6.4. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайн жилд үйлдвэрлэсэн, борлуулсан бүтээгдэхүүний мэдээг улсын хэмжээгээр нэгтгэн холбогдох маягтын дагуу тайлан гаргаж, нийтэд мэдээлэх;

6.5. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-ын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон

нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн тайлан, түүнийг нийтэд мэдээлсэн товч тайлангийн хамт аж ахуйн нэгж бүрээс гаргуулан авч санаачилгын бие даасан ажлын албанд хүргүүлэх;

6.6. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын албанд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

7. Төрийн өмчийн хороо олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийн удирдлагад санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулах;

7.2. санаачилгын тайлан гаргах арга зүй, заавраар аж ахуйн нэгжийн удирдлага болон бүртгэл, санхүүгийн ажилтныг хангах;

7.3. төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийн газраас хүлээн авсан төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн тайланг аж ахуйн нэгж бүрийн нэрээр санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

8. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулсны ажлын байрны тухайн жилийн хүлээн авсан төлбөрийг аж ахуйн нэгж бүрийн нэрээр санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

9. Улсын мэргэжлийн хяналтын төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгахдаа санаачилгыг хэрхэн хэрэгжүүлж байгааг холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хүрээнд шалгаж, нийтэд мэдээлэх.

10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан оролцогч 3 талын ижил тэгш бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулах;

10.2. нутаг дэвсгэртээ орших олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулан тайлан гаргуулах, нийтэд мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

10.3. нутаг дэвсгэрт нь орших олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж санаачилгын тайлангаа гаргаж нийтэд мэдээлж байгаа байдалд хяналт тавих, энэ чиглэлээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

10.4. сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тухайн сум, дүүрэгт хүлээн авсан албан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, үзүүлсэн аливаа мөнгөн болон биет (машин, өвс тэжээл зэрэг) дэмжлэгийн талаархи мэдээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдээлэх;

10.5. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тухайн аймаг, нийслэлд хүлээн авсан албан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, үзүүлсэн мөнгөн болон биет (машин, өвс тэжээл зэрэг) дэмжлэгийн талаархи мэдээг сум, дүүргээс ирүүлсэн энэхүү чиг үүргийн 10.4-т заасан мэдээтэй нэгтгэн санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх;

10.6. санаачилгыг хэрэгжүүлэх, цаашид тогтворжуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 03 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар
хот

Журам, жагсаалт батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 7.5, 60.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Газар өмчлөгч, эзэмшигчийн ашиг олох зорилгогүйгээр өөрийн ахуйн хэрэгцээнд тухайн газартаа ашиглаж болох түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалт"-ыг 1 дүгээр, "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч

Н.Баяртсайхан, энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүх нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 234 дүгээр тогтоол, "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД БӨГӨӨД
ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАЯРТСАЙХАН

Засгийн газрын 2007 оны 81 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗАР ӨМЧЛОГЧ, ЭЗЭМШИГЧИЙН АШИГ ОЛОХ ЗОРИЛГОГҮЙГЭЭР ӨӨРИЙН АХУЙН ХЭРЭГЦЭЭНД ТУХАЙН ГАЗАРТАА АШИГЛАЖ БОЛОХ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ЖАГСААЛТ

1. Тоосгоны шавар
2. Элс
3. Хайрга

4. Барилгын чулуу
5. Шохойн чулуу

Засгийн газрын 2007 оны 81 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТӨСВӨӨС ХАЙГУУЛЫН АЖИЛД ГАРСАН ЗАРДЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ, ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улсын төсвийн хөрөнгөөр нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын бүх шатны ажил (цаашид "хайгуулын ажил" гэх)-ыг хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж (цаашид "аж ахуйн нэгж" гэх)-ээр уг зардлыг улсын төсөвт нөхөн төлүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлүүлэхэд улсын төсвөөс ашигт малтмалын ордыг илрүүлэн нөөцийг тогтооход зарцуулсан нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын бүх шатны ажлын зардал (цаашид "хайгуулын ажлын зардал" гэх)-ууд хамрагдана.

3. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлыг судалж, зардлыг нөхөн төлүүлэх гэрээг аж ахуйн нэгжтэй байгуулан нөхөн төлүүлэх үйл ажиллагааг хангах үүргийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх) хариуцна.

Хоёр. Хайгуулын ажлын зардлыг нөхөн
төлүүлэх үндсэн аргачлал

4. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг Геологийн мэдээллийн төвд хадгалагдаж байгаа тухайн ордын хайгуулын ажлын тайланд тусгасан зардлыг үндэслэн тогтооно.

5. Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгосон ордын хайгуулын ажлын нөхөн төлөх зардлын хэсэг

болох нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын зардлыг тооцохдоо тухайн ордоод хамрагдсан талбайд хийгдсэн эдгээр ажлын зардлын 1 гектарт ногдох зардлын хэмжээг тайланд тусгагдсан зардлыг үндэслэн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нийт гектараар үржүүлэн тооцно.

6. 1991 оны 1 дүгээр сарын 16-наас өмнө төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоол гарсантай холбогдуулан цалинг 2 дахин, бусад материаллаг зардлыг 1.75 дахин нэмэгдүүлж тооцно.

7. Хайгуулын ажлын анхны зардлын доторхи цалингийн зардлыг 25 хувиар, материаллаг зардлыг 75 хувиар тооцож дараахь байдлаар хайгуулын ажлын зардлыг 1991 оны 1 дүгээр сарын 16-ны түвшинтэй харьцуулан шинэчлэн тогтооно:

$${}^1\text{НЭЭYXАШЗ}^{1991} = ({}^2\text{НЭЭYXААЗ}^0 \cdot 0.25^2) + ({}^3\text{НЭЭYXААЗ}^0 \cdot 0.75 \cdot 1.75)$$

8. Энэ журмын 7-д заасан аргачлалын дагуу тооцсон зардлыг 1991 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийг суурь болгон авч хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин (ЕТ)-гээр үржүүлэн хайгуулын ажлын шинэчилсэн зардлыг тооцно. Ерөнхий түвшинг тооцохдоо гэрээ байгуулахын өмнөх онд Үндэсний статистикийн газраас ирүүлсэн албан ёсны үнэ, тарифын индексийн мэдээллийг үндэслэнэ.

$${}^4\text{НЭЭYXАШНЗ}^{1991} = \text{НЭЭYXАШЗ}^{1991} \cdot \text{ЕТ}^{1991}$$

Гурав. Хайгуулын ажлын нөхөн төлбөр хийх аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

9. Аж ахуйн нэгж нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш тусгай зөвшөөрлөөр олгосон талбайд улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал байгаа эсэхийг төрийн захиргааны байгууллагаар шалгуулж ажлын 30 хоногийн дотор гэрээ байгуулах хүсэлтээ гаргана.

10. Гэрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн дарга (захирал) гарын үсэг зурж баталгаажуулна.

11. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авч байгаа хуулийн этгээд нь хайгуулын ажлын нөхөн төлбөрийн өмнөх гэрээний төлбөрийг дүүнүүлж шинэчлэн гэрээ байгуулна.

12. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө барьцаалсан бол энэ тухай баримтыг ажлын 20 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Дөрөв. Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

13. Төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 9-д заасан гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн аваад ажлын 30 хоногийн дотор ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын хэмжээг энэхүү журмын 2-т заасан аргачлалын дагуу тооцон гаргана.

14. Төрийн захиргааны байгууллага энэхүү журмын хоёр дахь зүйлд заасан аргачлалын дагуу тооцон гаргасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөрийн гэрээ байгуулах аж ахуйн нэгжийг танилцуулан гэрээ байгуулах саналыг тавина.

15. Төрийн захиргааны байгууллага гэрээ байгуулах санал тавьснаас хойш ажлын 30 хоногийн дотор гэрээг байгуулна.

16. Гэрээнд төрийн захиргааны байгууллагын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож гэрээ байгуулах үйл ажиллагаанд тавих хяналт

17. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцон тогтоож гэрээ байгуулах үйл ажиллагаа болон төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний биелэлтэд геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, улсын мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

Зургаа. Бусад

18. Гэрээний загварыг төрийн захиргааны байгууллагын дарга батална.

19. Гэрээг монгол хэл дээр үйлдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд англи хэл дээр орчуулан хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулна.

20. Гэрээг гурван хувь үйлдэж нэг хувийг төрийн захиргааны байгууллага, нэг хувийг гэрээ

Тайлбар:

¹ Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолын дагуу 1991 оны түвшинтэй харьцуулан шинэчлэн, тусгаасон нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын шинэчилсэн зардал

² нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын анхны зардал

³ гэрээ байгуулсан оны нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын шинэчилсэн нийт зардал

⁴ гэрээ байгуулахын өмнөх оны ерөнхий түвшин



байгуулагч аж ахуйн нэгж, нэг хувийг мэргэжлийн хяналтын төв байгууллага хадгална.

тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

21. Гэрээнд заасан үүргийн биелэлт болон бусад асуудлаар гарсан маргааныг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд

22. Аж ахуйн нэгж нөхөн төлбөрөө гэрээнд заасан хугацаандаа төлөөгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60.7, 60.9-д заасан хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

өдрийн 287 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

"Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай" Улсын Их Хурлын 2007 оны 9 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1996 оны 11 дүгээр сарын 28-ны

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

эрхийн улсын бүртгэлийн газрын даргаар томилсугай.

Дагвадоржийн Долгормааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эд хөрөнгийн

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД
БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Давс иоджуулж, иод дутлаас сэргийлэх тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр баталж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Эрүүл мэндийн сайд Д.Туяа нарт үүрэг болгосугай.

1. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" III хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлж, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Эрүүл мэндийн сайд Д.Туяа, Сангийн сайд Н.Базартсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД Д.ТЭРБИШДАГВА
ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД Д.ТУЯА

"ИОД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ" III ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Иодын дутал нь хүний, ялангуяа бага насны хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдар, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлж, оюуны чадамжийг 10-15 хувиар бууруулдгийг олон оронд хийсэн судалгаа, шинжилгээний дүн нотолжээ. Дэлхийн 100 гаруй орны нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан зорилтын нэг нь иод дутлын эмгэгтэй тэмцэх явдал болж байна. АНУ-д хуралдсан 2002 оны Дэлхийн хүүхдийн дээд хэмжээний уулзалтаас дэлхий дахинаа иод дутлын эмгэгийг устгах асуудлыг хүн төрөлхтний эрүүл мэндийн салбарын чухал зорилт болгон дэвшүүлсэн.

Монгол Улсын хүн амын 80 гаруй хувь нь иодын дуталтай бүс нутагт оршин суудаг. Ийм учраас Засгийн газраас иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөрийг 2 удаа батлан хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрүүдийн хүрээнд дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн иод дутлын эмгэгтэй тэмцэх арга болох давсыг иоджуулан хүнс, малын тэжээлд хэрэглэх техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамж, хэрэглээг дэмжих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, хянах, мэдээлэх тогтолцоог бий болгох, малын иод дутлын эмгэгийн тархалтыг аймаг бүрээр судлан тогтоож, иоджуулсан тэжээл бэлдмэлийн жорыг боловсруулах, иод дутлын эмгэгийн тархалтын бууралтыг үнэлэх, түүнтэй уялдуулан бүс нутгуудад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулсан болно.

2. Хөтөлбөр хэрэгжих явцад давсны 10 орд газрыг тодорхой эзэмшилтэй болгож тэдгээрийг түшиглэн иоджуулсан давсны жижиг, дунд үйлдвэр 21-ийг байгуулла. Тухайн ордын дэргэд бассейний байгуулан давсыг талстжуулж олборлох технологийг давсны 2 ордод туршсан нь амжилттай болсон. 2005 оны байдлаар дотоодын болон импортын 8.4 мянган тонн иоджуулсан давс хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн нь нийт хэрэглээний давсны 89 хувь болж байна. 1992 онд хүн амын иод дутлын эмгэгийн тархалт 29.2 хувь байсан бол хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд 2004 оны "Эх, хүүхдийн хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгөх" үндэсний 3 дугаар судалгаагаар 13.8 хувь болж бууран, айл өрхийн 74.4 хувь нь иоджуулсан давс тогтмол хэрэглэж олон улсын жишиг үнэлгээгээр Монгол Улс иод дутлын эмгэгийн "дунд" зэргийн тархалттайгаас "зөнгөн" зэргийн тархалттай оронд хамаарах болоод байна.

Малын иод дутлын эмгэгийн тархалтыг өмнө нь судлаагүй байсан бүх аймгийг судалгаанд

хамруулан судалгааны материалтай боллоо. Мал иод дутлаас шалтгаалан гаж буруу хөгжилтэй буюу үхсэн төл гаргах, хээл хаях, сувайрах, ноос, ноолуур, сүү, махны ашиг шим нь 5-15 хувиар буурах, төл малын өсөлт, хөгжилт саатаж өвчинд нэрвэгдэмтгий болох зэрэг сөрөг үр дагавартай болох нь тогтоогджээ.

Улсын дунджаар малын иод дутлын эмгэгийн тархалт 13.2 хувьтай байгаа боловч төвийн бүс, ялангуяа Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймагт энэ үзүүлэлт 24-30 хувьд хүрч байна. Судалгааны явцад иоджуулсан эрдэс долооц үйлдвэрлэн мал, амьтанд өгч туршсан нь үр дүнгээ өгч байна.

3. Иод дутлын эмгэгтэй тэмцэх II хөтөлбөрийн зорилтууд 90 орчим хувиар биелж, тодорхой үр дүн гарсан боловч хүн амын дундах үг эмгэгийн тархалтыг 5-аас доош хувь хүртэл бууруулах, өрхийн иоджуулсан давсны хэрэглээг үндэсний хэмжээнд 95 хувьд хүргэх зорилтдоо хараахан хүрсэнгүй. Иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлийн тоо хэмжээ өсч байгаа боловч орон нутгийн хэрэгцээг хангахаас хэтрэхгүй, хөрөнгө оруулалт, санхүүжилтээс хамаарч чанамал давс үйлдвэрлэх улсын хэмжээний томоохон үйлдвэр байгуулах зорилт хэрэгжсэнгүй.

Сум, хөдөөгийн айл өрхийг иоджуулсан давсаар хангах борлуулалтын сүлжээг орон нутагт зохион байгуулах асуудал харилцан адилгүй байгаагаас иоджуулсан давсны хэрэглээ жигд тогтмолжиж чадахгүй байна. Үүнээс шалтгаалан өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээ баруун бүсэд 58 хувь ("Хүүхэд хөгжил-2005" судалгаа) байгаа нь улсын дунджаас 25 хувиар доогуур байна. Иоджуулсан давсны хэрэглээг тодорхойлох үндсэн шалгуур болох 7-11 насны хүүхдийн шээсээр ялгарах иодын хоногийн хэмжээ 100-200 мкг/л байвал тухайн хүний иодын хэрэглээг зохистой гэж үздэг. Гэтэл 2004 оны судалгаагаар энэ үзүүлэлт 96.6 мкг/л байгаа төдийгүй 52.9 хувьд нь иоджуулсан давсны хэрэглээг зохистой түвшинд хүрээгүй байна.

4. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, иод дутлын эмгэгийг дэлхий нийтээрээ устгах тухай олон улсын байгууллагуудын өмнө Монгол Улсын авсан амлалт, 2003 оны Бээжингийн уулзалтаар иод дутлын эмгэгийг устгах ажлыг эрчимтэй зохион байгуулахаар хүлээнэ үүргээ биелүүлэх, 2008 оны 4 дүгээр сард хуралдсан "Иод дутлын эмгэгтэй тэмцэх ажлын хэрэгжилт, үр дүн" үндэсний бага

хурал, төслийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээний зөвлөмжүүдийг ажил хэрэг болгох, Монгол Улс иод дутлын эмгэгийг устгасан орны тоонд дэвшин орж ард иргэдээ уг эмгэгийн хор хөнөөлөөс ангижруулах зорилгоор "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" III хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн үндсэн зорилго

5. Хүн амыг чанартай, аюулгүй иоджуулсан үндэсний үйлдвэрлэлийн давсаар хангах хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглээг тогтмолжуулан хэвшүүлэх замаар иод дутлын эмгэгийн тархалтыг 5-аас доош, иоджуулсан давсны хэрэглээг 95-аас дээш хувьд хүргэх, иоджуулсан тэжээлийн үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар малын иод дутлын эмгэгийг бууруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, эдгээр зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ

6. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

7. Нэгдүгээр зорилт: Давсны ордыг эзэмшилтэй болгох, иоджуулсан давс, эрдэс тэжээл, эм, бэлдмэлийн үндэсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, техник, технологийн шинэчлэл нэвтрүүдэх ажлыг бодлогоор дэмжинэ.

Энэхүү зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

7.1. хүнс, малын тэжээлийн давсны ордуудыг түгээмэл тархацтай ашигт малтмалын жагсаалтад хамруулах;

7.2. тодорхой эзэмшилгүй болон хэсэгчилсэн эзэмшилтэй давсны ордын эзэмшилгүй хэсгээс давс олборлоход нутгийн захиргааны болон иргэдийн хяналт тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

7.3. судалгаа хийгдсэн давс, хужир, шүүний ордын ашиглалтын байдлыг судалж стратегийн ач холбогдол бүхий зарим ордод нарийвчилсан үнэлгээ хийлгэх;

7.4. малын тэжээлийн зориулалтаар давс, шүү, хужир олборлож, иоджуулан савлаж борлуулах үйлдвэрлэл эрхлэж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нутгийн захиргаанаас дэмжлэг үзүүлэх, хяналтыг сайжруулах;

7.5. иоджуулсан давс, малын эрдэс тэжээл, эм, бэлдмэлийн үндэсний үйлдвэрлэлийг өргөжүүлж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн үндэсний хэмжээний томоохон үйлдвэр

байгуулах төсөл боловсруулан хандивлагчдад санал болгох, Засгийн газрын зүгээс дэмжлэг үзүүлэх;

7.6. шаардлагатай бүх суманд иоджуулсан давсны борлуулалтын эргэлтийн санг байгуулан хөдөөгийн хүн амыг иоджуулсан давсаар тогтмол хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.

8. Хоёрдугаар зорилт: Иоджуулсан хүнсний давс болон малын тэжээл бэлдмэлийн үйлдвэрлэл, хангамж, хэрэглээ, үйлчилгээг хянах, мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгоно.

Энэхүү зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

8.1. малын иоджуулсан тэжээлийн стандарт, техникийн нөхцөлийг боловсруулан мөрдүүлэх;

8.2. иоджуулсан хүнсний давс, малын эрдэс тэжээлийн үйлдвэрлэл, импорт, тээвэрлэл, хадгалалт, хангамж, хэрэглээнд тавих хяналтыг тогтмолжуулж, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

8.3. иоджуулсан давс, малын эрдэс тэжээл, эм, бэлдмэлийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чанарт тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг сайжруулах, тогтмолжуулах;

8.4. хөтөлбөрийн үр нөлөөллийг олон улсын шинжээчидтэй хамтран судалгаа хийж дүгнэлт гаргах.

9. Гуравдугаар зорилт: Хүн, малын иод дутлын эмгэгийг хянах тандалтыг тогтворжуулан.

Энэхүү зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

9.1. үндэсний хэмжээнд иод дутлын эмгэг (бахлуур, шээсэн дэх иодын агууламж, нярайн цусан дахь бамбай эрчимжүүлэгч дааврын хэмжээ)-ийн тархалт, иоджуулсан давсны хэрэглээ, оюуны чадамж зэрэг үзүүлэлтийг хөтөлбөрийн эхэнд болон төгсгөлд бүсчилсэн судалгаагаар тодорхойлж, дүгнэлт өгч үр дүнг нийтэд мэдээлэх;

9.2. иод дутлын эмгэгтэй тэмцэх орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтыг хянах, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах ажлыг бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн хийх, үйл ажиллагааг тогтворжуулах;

9.3. төл малын иод дутлын эмгэгийн тархалтыг 5 жил тутам бүсчилсэн түүвэр судалгаагаар тогтоож нийтэд мэдээлэх;

9.4. давсны орд, үйлдвэрлэл, хангамж, хэрэглээ, борлуулалт, иод дутлын эмгэгийн тархалтын талаар мэдээллийн нэгдсэн сан байгуулах. ВЕБ хуудас ажиллуулах.

10. Дөрөвдүгээр зорилт: Иод дутлын эмгэгийн талаархи хүн амын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг тогтмолжуулах, мэдээллийг хүртээмжтэй болгох замаар иоджуулсан давсны хэрэглээг хэвшүүлнэ.

Энэхүү зорилтыг дараахь арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

10.1. хүн, малын мэргэшсэн эмч нар, давс, эрдэс тэжээлийн үйлдвэр, үйлчилгээний ажилтан, ажилчид, лабораторийн шинжээч, бүх шатны албан болон албан бус сургалтын сургагч багш, мэргэжлийн хяналтын байцаагч нарт зориулан төрөлжсөн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

10.2. иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаар бус нутаг, тодорхой бүлгийн хүн амд зориулан сургалт, сурталчилгааг хийх, мэдээллийн хүртээмжийг сайжруулан тэдгээрийн тасралтгүй, тогтвортой байдлыг хангах;

10.3. малын иод дутлын эмгэг, түүний хор уршгийн талаар мал аж ахуйн мэргэжилтэн, аймаг, сум, багийн удирдлага, малчдын дунд өргөн хүрээтэй сурталчилгаа зохион байгуулах;

10.4. иоджуулсан давс, эрдэс тэжээлийг хэрэглэсний ач холбогдол, иод дутлын эмгэгийн хор хөнөөл, судалгааны үр дүнг тусгасан мэдээлэл болон сургалтын гарын авлага, сурталчилгааны материалыг боловсруулж түүгээх;

10.5. иод дутлын эмгэг, иоджуулсан давс, малын эрдэс тэжээл, эм бэлдмэлийн талаар гадаад болон дотоодын үйлдвэрүүд, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулах, гадаадын ижил төрлийн арга хэмжээнд оролцох, харилцан туршлага солилцох.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжих хугацаа, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

11. Хөтөлбөрийг 2007 оноос эхлэн 4 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлнэ.

12. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг Хүнсний салбарын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

13. Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам эрхэлнэ.

14. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг Үндэсний хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

15. Аймаг, нийслэл бүр дэд хөтөлбөр боловсруулан Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.

16. Аймаг, нийслэлийн дэд хөтөлбөрийн зөвлөлийн дарга, бүрэлдэхүүн, жилийн ажлын төлөвлөгөөг Засаг дарга баталж биелэлтэд хяналт тавина.

17. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар жил бүрийн 1 дүгээр сард багтаан Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тайлагнана. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь Эрүүл мэндийн яамтай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайланг гаргаж Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, Хүнс, хөдөө аж ахуйн сайд жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

18. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

18.1. улсын болон орон нутгийн төсөв;

18.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

18.3. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

18.4. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

18.5. гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалт.

Тав. Хамтын ажиллагаа, түншлэл, олон нийтийн оролцоо

19. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын бусад байгууллага, хандивлагч орны дэмжлэгийг авч, төрийн болон төрийн бус байгууллага, бусад оролцогч аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

20. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарим үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлт

даргын Тамгын газар, үр дүнгийн үнэлгээг Эх хүүхдийн хоол тэжээлийн байдалд хийх үнэлгээгээр хийнэ.

21. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээг Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг

22. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн түвшин (2004, 2006)	Хүрэх түвшин (2010)	Мэдээллийн эх үүсвэр
1	7-11 насны хүүхдүүдийн дундах бахлуурын тархалтын хувь	13.8	< 5.0	Судалгаагаар НЭМХ, НҮБХС
2	7-11 насны хүүхдүүдийн шээсэн дэх иодын агууламж 100 мкг/л-ээс бага байх хувь	52.5	< 50.0	Судалгаагаар НЭМХ, НҮБХС
3	Нярайн цусан дахь БЭД оун/мл-ээс их байх хувь	7.1	< 4.0	Судалгаагаар НЭМХ, НҮБХС
4	Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний хувь	74.4	95.0	Судалгаагаар НЭМХ, НҮБХС
5	Иоджуулсан хүнсний давсны хангамж	90.0	100.0	ХХААЯ-ны тайлан мэдээ
6	Иоджуулсан эрдэс, тэжээлийн үйлдвэр	2.0	3.0	ХХААЯ-ны тайлан мэдээ
7	Малын иод дутлын эмгэгийн тархалт	13.2	10.0	Судалгаагаар ХААИС, МЭХ

23. Зорилтын шалгуур, хүрэх түвшин (аймаг, бүсээр)

№	Аймаг, нийслэлийн зор	Бахлуурын тархалтын түвшин (2004)	Бахлуурын тархалтыг бууруулах түвшин (2010)	Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний өнөөгийн байдал (%)	Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний хүрэх түвшин (%)	Малын иод дутлын эмгэгийн тархалтын өнөөгийн түвшин (2005)	Малын иод дутлын эмгэгийн тархалтыг бууруулах түвшин (2010)
1	Баян-Өлгий	14.4	8.3	44.1	80.0<	15.0	12.0
2	Говь-Алтай	10.2	<5.0	54.8	80.0<	10.2	8.0
3	Завхан	21.7	15.0	61.9	80.0<	11.6	7.0
4	Увс	18.4	12.4	25.0	80.0<	14.0	10.0
5	Ховд	11.1	<5.0	29.5	80.0<	13.5	10.0
	Баруун бүс			42.2	80.0<		
6	Дорнод	10.0	<5.0	71.4	95.0<	19.0	10.0
7	Хэнтий	10.0	<5.0	97.5	95.0<	24.0	20.0
8	Сүхбаатар	15.0	9.0	66.7	95.0<	9.0	5.0
	Зүүн бүс			79.6	95.0<		
9	Дорноговь	11.7	<5.0	90.5	95.0<	2.9	1.0
10	Дундговь	10.0	<5.0	90.5	95.0<	-	-
11	Өмнөговь	3.3	<5.0	70.0	95.0<	-	-
	Говийн бүс			85.5	95.0<		
12	Архангай	20.0	14.0	63.5	95.0<	20.0	15.0
13	Баянхонгор	8.3	<5.0	73.8	95.0<	12.8	8.0
14	Булган	13.3	7.3	67.4	95.0<	32.8	20.0
15	Говьсүмбэр	-	-	-	95.0<	8.7	5.0
16	Дархан-Уул	16.7	10.5	69.6	95.0<	30.0	20.0
17	Орхон	11.7	<5.0	80.5	95.0<	35.0	20.0
18	Өвөрхангай	13.3	7.0	66.1	95.0<	16.5	10.0
19	Сэлэнгэ	15.0	8.0	81.4	95.0<	34.0	25.0
20	Төв	13.3	8.0	86.4	95.0<	15.5	10.0
21	Хөвсгөл	25.6	18.0	54.8	95.0<	33.0	20.0
22	Улаанбаатар	12.5	<5.0	95.9	95.0<	0.2	<0.1
	Төвийн бүс			82.3	95.0<		
	Улсын дундаж	13.8	<5.0	=74.4	95.0<	13.2	<10.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 50 жилийн ойг 2009 оны 11 дүгээр сард тэмдэглэх болсонтой холбогдуулан 2 жилийн бүтээлч ажил өрнүүлж, ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Ой угтсан бүтээлч ажлын тухай

2. Ой угтсан бүтээлч ажлыг хэрэгжүүлэх болон тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД**
Д.ТЭРБИШДАГВА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуулийн 47.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэрийг 1 дүгээр хавсралт ёсоор, зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж нийтэд зарласугай.

2. Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг энэхүү тогтоолын 1, 2 дугаар

Биржийн нэр зарлах тухай

хавсралтаар баталсан бирж болон зах зээлийн үнэтэй жишиг үнэлэх аргачлал боловсруулж мөрдөхийг Сангийн сайд Н.Баяртсайханд, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг 2007 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
САНГИЙН САЙД
Н.БАЯРТСАЙХАН

Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УУЛ УУРХАЙН ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ БОЛГОХ ОЛОН УЛСЫН ЖИШИГ ҮНЭ ТОГТООДОГ БИРЖ

- | | |
|-------------------|--------------------------|
| 1. Зэс | Лондонгийн металлын бирж |
| 2. Цайр | Лондонгийн металлын бирж |
| 3. Цагаан тугалга | Лондонгийн металлын бирж |
| 4. Хар тугалга | Лондонгийн металлын бирж |

Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАРИМ ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ БОЛГОХ МОНГОЛ БАНКНЫ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ЭХ СУРВАЛЖИЙН НЭР

- | | | | |
|----------|---|----------|--|
| 1. Алт | Тухайн өдрийн Монгол банкнаас зарласан үнэд үндэслэнэ | 3. Төмөр | Австралийн төмрийн үйлдвэрлэгч, Японы ган үйлдвэрлэгчийн хоорондын худалдааны гэрээнд заасан үнэ |
| 2. Мөнгө | Тухайн өдрийн Монгол банкнаас зарласан үнэд үндэслэнэ | 4. Жонш | Гол экспортлогч Хятад, гол |

5. Молибден

 импортлогч АНУ-ын худалдааны гэрээнд заагдсан үнэ
Интернэйшнл молибден
байгууллагын зарласан үнэ

6. Нүүрс

Хятадын нүүрсний үйлдвэрлэлийн талаархи мэдээлэл сэтгүүл (China Coal weekly www.coalword.net)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын 2007 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2007 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сар тутам төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2006 онд тогтоосон түвшинд үргэлжлүүлэн мөрдсүгэй.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцдаг даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын хураамжийг 300 төгрөгөөр, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн

сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний сарын хураамжийг 500 төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний сарын хураамжийг 2550 төгрөгөөр тус тус тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД**
Д.ТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатарт даалгасугай.

3. Олон жил гантай байгаа говь, тал хээрийн бүс нутагт 2007 онд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд шаардагдах 105.8 (нэг зуун таван сая найман зуун мянга) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас

гаргахыг Сангийн сайд Н.Баяртсайханд зөвшөөрсүгэй.

4. Хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны аюулгүй байдлыг бүх талаар найдвартай хангуулж, экспедиц ажиллах хугацаанд ажлын явц, үр дүнг 14 хоног тутамд Засгийн газарт мэдээлж байхыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**
И.ЭРДЭНЭБААТАР
Засгийн газрын 2007 оны 85 дугаар тогтоолын хавсралт

ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ 2015 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Оршил

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ган, цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутгийн байгаль орчны төлөв байдлыг дэмжих зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийн зорилт нь:

- хөрсний чийг, таримал болон бэлчээрийн ургамлын ургац, гол мөрөн, нуур, цөөрөм, усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлэх;

- целжилт, элсний нүүдэл, хөрсний эвдрэлийг багасгах;
- хүч, техник хүрэх боломжгүй ой хөвчийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх;
- таримал ургамлыг мөдрөөс хамгаалах;
- шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурлан цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронгуй болгоход оршино.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улам бүр хувиран өөрчлөгдөж байгаа байгаль орчны уур амьсгал, усны нөөцийг нийгмийн хэрэгцээнд зүй зохистой ашиглах, байгаль, цаг агаарын гамшигт үзэгдлийн сөрөг нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэх болно.

Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь дараахь нөхцөл, байдлаас урган гарч байна:

1.1. Дэлхийн дулаарлын улмаас манай орны уур амьсгал эрс өөрчлөгдөж, байгаль, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж, улс орны нийгэм, эдийн засагт учрах хохирлын хэмжээ өсөх хандлагатай байна. Тухайлбал, сүүлийн жар гаруй жилийн дотор намар, өвлийн хур тунадасны хэмжээ бага зэрэг өсч, хавар, зуны хур тунадасны хэмжээ буурсны дотор ургамал ургалтын хугацаанд хур тунадастай өдрийн тоо бараг нийт нутгаар өссөн атал хур тунадасны хэмжээ 7.2 хувиар буурсан байна. Судалгаанаас үзэхэд зүс хур тунадасны тохиолдлын тоо цөөрч, аадар хур тунадасны давтамж өссөн байна.

1.2. Хур тунадасны горимын өөрчлөлттэй уялдан байгалийн төрх байдал, хөрс ургамлын бүтцэд өөрчлөлт гарч говь, хээрийн бүс хойд зүг рүү түрж, олон тооны нуур, тойром, булаг, шанд, голууд ширгэж байгаагаас целжилт эрчимжиж, гангийн давтамж ихэсч, хамрах талбай нь нэмэгдэж байна. Энэ нь бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, ард иргэдийн амьдрал, улмаар улс орны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ авахын зэрэгцээ цаг агаарын тааламжтай нөхцөл, боломжийг ашиглан нөхцөл бүрдсэн үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасыг нэмэгдүүлэх нь ган, целжилтөд нэрвэгдэж байгаа бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулах боломжтой юм.

Хоёр. Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаар баримтлах чиглэл

2.1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх талаар дараахь чиглэлийг баримтлана:

2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг боловсронгуй болгох;

2.1.2. цаг уурын суурин болон хөдөлгөөнт радар, нисэх онгоц зэрэг цаг агаарт зориудаар нөлөөлөх орчин үеийн техник, технологи бүхий сүлжээ байгуулах;

2.1.3. цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын технологийг боловсронгуй болгох, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлын хүрээг өргөтгөх;

2.1.4. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны мэдээлэл дамжуулах, хүлээн авах нэгдсэн тогтолцоог бий болгох;

2.1.5. хур тунадас хэмжих улсын сүлжээг өргөтгөх;

2.1.6. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, төв, орон нутгийн байгууллага, сүлжээг боловсон хүчнээр хангах асуудлыг дэс дараатай шийдвэрлэх.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1. холбогдох эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.2. цаг агаарт зориудаар нөлөөлөх аюулгүй ажиллагааны журам, технологийн зааврыг боловсруулж мөрдүүлэх.

3.2. Цаг уурын суурин болон хөдөлгөөнт радар, нисэх онгоц зэрэг цаг агаарт зориудаар нөлөөлөх орчин үеийн техник, технологи бүхий сүлжээ байгуулах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.2.1. цаг агаарт зориудаар нөлөөлөх нөхцөл бүрдсэн үед тухайн бүс нутагт уг ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий бүсийн төв байгуулах;

3.2.2. цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах, агаарын хөлийн нислэгийн аюулгүй байдлыг хангах, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай үүлний тархалт, түүний физик үзүүлэлт болон хур тунадасны эрчимшил, нам өндрийн салхины орныг тодорхойлох радарын сүлжээг бүсчлэн байгуулах;

3.2.3. гол мөрөн, усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлэх, зохистой хэмжээнд байлгах зорилгоор зарим гол мөрний ай савын өндөрлөг газруудад хур тунадас нэмэгдүүлэх газрын генератор суурилуулах, шаардлагатай бүс нутагт хөдөлгөөнт экспедиц ажиллуулах;

3.2.4. хур тунадасны хэмжээ, тархацыг тодорхойлох зорилгоор физик газарзүйн онцлогтой уялдуулан хур тунадас хэмжих автомат болон энгийн ажиллагаатай цэг байгуулах.

3.3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын технологийг боловсронгуй болгох, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлын хүрээг өргөтгөх талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1. Монгол орны үүлний нөөц, түүний бүтэц, физик үзүүлэлтүүдийг тогтоох зорилгоор үүлний бичил бүтцийг судлах лаборатори байгуулах;

3.3.2. судалгааны үр дүнг нэгтгэн цаг агаарт зориудаар нөлөөлөх чиглэлээр мэдээллийн сан байгуулах;

3.3.3. цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын үр дүнг үнэлэх аргачиллыг боловсруулж мөрдөх.

3.4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны мэдээлэл дамжуулах, хүлээн авах нэгдсэн тогтолцоог бий болгох чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага болон орон нутаг дахь салбар, хөдөлгөөнт экспедицийн хооронд зураг, мэдээлэл солилцох үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, мэдээллийн технологи нэвтрүүлэх.

3.5. Хур тунадас хэмжих сүлжээг өргөтгөх чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1. цаг уурын өртөө, харуул байхгүй газарт хур тунадас хэмжих автомат болон энгийн ажиллагаатай хэмжлийн багаж байрлуулан ашиглах;

3.5.2. цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагт гол мөрөн, нуурын усны түвшний хэмжлийн цэгүүдийг байгуулах.

3.6. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, төв, орон нутгийн сүлжээг боловсон хүчнээр хангах асуудлыг дэс дараатай шийдвэрлэх талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.6.1. цаг агаарт зориудаар нөлөөлөх чиглэлээр боловсон хүчнийг мэргэшүүлэх, давтан сургах тусгай сургалтыг зохион байгуулах, гадаад дотоодын сургалтад хамруулах;

3.6.2. боловсон хүчний тогтвор суурьшил, нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэж, салбарын дундаж түвшингээс бууруулахгүй байх зарчим баримтлах.

Дорov. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх үндсэн дээр бэлчээрийн болон таримал ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ган, цөлжилтийг бууруулах, гол мөрөн, усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн, техник хүрэх боломжгүй ой хөвчийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

4.1. Байгаль орчны асуудал хариуцан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байна.

4.2. Хөтөлбөрийг ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа эрхлэх байгууллага хэрэгжүүлнэ.

4.3. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр зэрэг байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. улсын төсөв;

5.1.2. орон нутгийн төсөв;

5.1.3. олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж, төслийн хөрөнгө;

5.1.4. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний дагуу төлсөн орлого;

5.1.5. улсын захиалгаар гүйцэтгэх цаг агаарт зориудаар нөлөөлөх шинжлэх ухаан-технологийн төслүүдэд олгох хөрөнгө.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

6.1. Хөтөлбөрийг дараахь үе шаттай хэрэгжүүлнэ.

- Нэгдүгээр үе шат (2007-2008 он)

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, эхний ээлжинд хур тунадас нэмэгдүүлэх шаардлагатай байгаа газруудад цаг уурын хөдөлгөөнт радар, газрын генератор ажиллуулах, цөлжилт эрчимтэй явагдаж байгаа аймгуудад цаг агаарт зориудаар нөлөөлөх цэг, нэгж байгуулж, техник хэрэгсэлээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.

- Хоёрдугаар үе шат (2009-2012 он)

Цаг уурын суурин радар, газрын генератор, тодорхой бүс нутагт цаг агаарт зориудаар нөлөөлөх сүлжээний нэгжүүдийг нэмж цөлжилт эрчимтэй явагдаж байгаа бүс нутгийн 70-ээс доошгүй хувьд хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах чадавхийг бүрдүүлнэ.

- Гуравдугаар үе шат (2013-2015 он)

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг газар болон агаараас явуулах чадавхитай болж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийг хамруулна.



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасан "Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож

нэмэгдүүлнэ" гэдгийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэн тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан эсэхээс үл хамааран нэмэгдлийг авна гэж ойлгоно.

Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлж, мөн зүйлийн 2-т заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгон, хөдөлмөрийн хөлсний 1.5 хувиар нэмэгдэл авч буй даатгуулагчид тахир дутуугийн тэтгэврийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан "...хөдөлмөрийн хөлс" гэдэгт төрийн албан хаагчийн хувьд төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т зааснаар төрөөс олгож буй цалин хөлсийг ойлгоно.

Харин хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ажил олгогчоос олгож буй "хөдөлмөрийн хөлс" гэдэгт үндсэн цалин, ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, ажилтан үндсэн

ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хэвсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг биелүүлсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан тохиолдолд үндсэн цалингаас нь тооцож олгосон нэмэгдэл хөлснөөс гадна мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл хамаарна.

2. Мөн зүйл, хэсгийн "...хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлого" гэдэгт цалин хөлснөөс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд тодорхойлсноор ажил олгогчоос олгож байгаа байнгын шинжтэй орлогыг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хэс: «Төрийн мэдээлэл» эмлэгчийн зөвсгөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12,
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 2

☎ 329487